



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 08 өдөр Дугаар 13

Хэрлэн сум

ХИИ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 13 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд 65,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Малын гоц халдварт хонины цэцэг өвчний нөхцөл байдлын талаар танилцуулах,

2.Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийн төслийг танилцуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Малын гоц халдварт хонины цэцэг өвчний голомт бүхий газарт ажиллах алба хаагчдад шаардлагатай 50 ширхэг нэг удаагийн халдвар хамгааллын хувцсыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Мал эмнэлгийн газарт шийдвэрлэх,

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

1.2.Малын гоц халдварт хонины цэцэг өвчин гарсан сумдад шаардлагатай ариутгал халдваргүйтгэл хийх ариутгалын бодисын шаардагдах зардал болох 3,0 сая төгрөгийг аймгийн 2023 оны төсөвт тусгасан мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас зарцуулах,

1.3.Малын гоц халдварт хонины цэцэг өвчний хорио цээрийн дэглэм тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийг гаргах,

Хоёр: Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1.Малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсан сумдын хонин сүрэгт дархлаажуулалтыг эрчимжүүлэх,

2.2.Өвчлөл гарсан сумдын хонин сүрэгт угаалга хийж, үзлэг тандалтын ажлыг эрчимжүүлэх,

 Ш.Ёл
/ Б.Цогтбаяр

2.3.Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад албан бичгээр зөвлөмж хүргүүлэх,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.4.Мал эмнэлгийн газрын албан бичиг, зөвлөмжийн дагуу малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,

Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Мал эмнэлгийн газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа нарт:

2.5.Бүх сумдын Засаг дарга нартай цахимаар хуралдаж, малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээний талаар зөвлөмж чиглэл өгч ажиллахыг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

